



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын
тархалтын "Улбар шар" түвшинд шилжсэнтэй
холбогдуулан авах зарим арга хэмжээний
тухай

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 21 дүгээр хуралдааны тэмдэглэлийн VII-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Улсын онцгой комиссоос ТОГТООХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтыг бууруулах зорилгоор дараах үйлчилгээний газрууд /ресторан, лоунж, саун, бассейн, чийрэгжүүлэх, бялдаржуулах төв, амралт, сувилал/-ын үйл ажиллагааг түр зогсоох, зах худалдааны төв, бусад үйлчилгээний газруудын ажлын цагийн хуваарийг 20:00 цаг хүртэл тогтоож, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх, өдөр, цагийн болон бусад зохицуулалтын арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.
2. Эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгслийн нөөц бүрдүүлэх, халдварын хавьтлыг тогтоох, тандалт судалгааг эрчимжүүлэх, гэрийн тусгаарлалтад байгаа батлагдсан тохиолдолд тавих хяналтыг сайжруулах, гэрээр болон цахимаар эмчлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, тухайн өрхөд дархлаажуулалтын багц хүргүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.
3. Дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх, нийслэлийн хүн амыг 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор дархлаажуулалтад бүрэн хамруулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт үүрэг болгосугай.
4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар болон Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, чиг үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг Онцгой, Цагдаа, Тагнуул, Мэргэжлийн хяналт, Эрүүл мэндийн байгууллага (ХӨСҮТ)-ын төлөөллийг оролцуулан байгуулан ажиллуулж, Улсын онцгой комиссыг цаг үеийн шуурхай мэдээллээр хангаж ажиллахыг Тагнуулын ерөнхий газрын дарга, хурандаа П.Одонбаатарт даалгасугай.
5. 65-аас дээш насны ахмад настнуудыг хөл, хөдөлгөөн багатай үе /10:00-12:00 цагийн хооронд/-д зах худалдааны төв, хүнсний дэлгүүрээр үйлчлүүлэх талаар зөвөлгөө, мэдээлэл өгч ажиллахыг ЗГХЭГ-ын Олон нийттэй харилцах газрын дарга Ц.Ганзориг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Иргэд, олон нийтийн зүгээс халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэхэд тэдний оролцоог сайжруулах, харьяалах нутаг, дэвсгэр, сум, дүүрэг, баг, хороо, анхан шатны нэгжид ажиллаж буй хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан, олон нийтийн цагдаа нарын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, мэргэжлийн хяналтын байгууллагатай өдөр тутмын уялдаа холбоотой ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

7. Улаанбаатар хотод халдварын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг халдварын эсрэг хамтдаа нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх, аж ахуйн нэгж байгууллага, объектод тавих хяналт, шалгалтыг батлагдсан тушаал удирдамжийн дагуу үргэлжлүүлэн зохион байгуулж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт даалгасугай.

8. Нийслэлийн дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт халдвар, хамгааллын дэглэм сахиулах, Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн биелэлт хангуулах ажлыг дэд сайд нарт хариуцуулж, хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд С.Баатаржавт даалгасугай.

9. Уул уурхайн олборлолт, зам барилга, дэд бүтэц, хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах хүрээнд ажлын тусгай горим, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж ажиллахыг холбогдох сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

10. Хаврын тариалалтын ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулах, хэрэгцээт үр, бордоо, шатахуун, сэлбэг хэрэгсэл, ургамал хамгааллын бодис тээвэрлэх ажлыг саадгүй нэвтрүүлэх зорилгоор тариаланчид, ногоочид, зөгийчид, техник болон үр бордоо, ургамал хамгааллын бодис нийлүүлэгч диллер аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудыг PCR шинжилгээг үндэслэн нийслэл хот болон аймаг, сумаас нэн яаралтай гаргах ажлыг шуурхай зохион байгуулахыг аймаг, нийслэл, сумын Онцгой комисст даалгасугай.

11. Засгийн газрын тогтоолоор зөвшөөрөгдсөн хилийн боомтуудаар экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг тасалдалгүй нэвтрүүлэх боломжийг бүрдүүлж, холбогдох зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам тээврийн, хөгжлийн сайд Л.Халтар, Хил хамгаалах ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, хилийн боомт бүхий аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

12. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт болон голомт бүхий объект, байршилд халдваргүйжүүлэлтийн ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

13. Гадаадаас ирсэн иргэдийг тусгаарлах байранд ажиглах хугацааг 7 хоног болгон холбогдох журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, хурандаа Ж.Чүлтэмсүрэн нарт үүрэг болгосугай.

14. Халдварын эрсдэл өндөр байгаатай холбогдуулан төрийн байгууллагын ажилтан албан хаагчдыг 30 хүртэл хувиар ажиллуулах, бусад албан хаагчдыг ажил үүргээ зайнаас, цахимаар гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, албан байгууллага бүрт халдвар хамгааллын хатуу дэглэм сахиулж, ажлын тусгай горимд оруулах, зохион

байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг ЗГХЭГ-ын дарга, сайд Ц.Нямдорж, Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

15. Улаанбаатар хотын авто тээврийн шалган нэвтрүүлэх, хяналтын цэгүүдийн ойролцоо байршилд явуулын PCR шинжилгээний цэг байгуулж ажиллуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай.

16. Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээнээс бусад төрийн бүх байгууллага, хуулийн этгээд, иргэн нэг дор 5-аас дээш хүн цуглуулахгүй байх дэглэм, журмыг чанд мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг бүх шатны Онцгой комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

17. Төрийн болон орон нутгийн өмчид байгаа нийтийн тээвэр үйлчилгээнд болон эмнэлгийн тусламж, тандалт судалгаанд шаардагдах автобус, автомашин, техник, тоног төхөөрөмжийн жагсаалт бүртгэлийг гаргаж, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Улсын онцгой комиссын мэдэлд ашиглуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэлд даалгасугай.

18. 65-аас дээш насны, суурь өвчтэй, эрүүл мэндийн эрсдэл бүхий ахмад настан, зорилтот бүлгийн өрх, иргэдэд хүнсний дэмжлэг үзүүлэх талаар судалж, танилцуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян нарт даалгасугай.

Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Амгалан, Шадар сайдын зөвлөх, шуурхай штабын хяналт, шалгалтын бүлгийн ахлагч П.Оюунчимэг нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН